



Манлайллын зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт
<p>2. Байгууллагын ил тод байдлыг хангах талаар:</p> <p>Зорилт-1: Хэлтсийн цахим хуудасны хэрэглэгчийн хүрээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, үйл ажиллагааг сурталчлах</p> <p>Зорилт-2: Хүний нөөцийн ил тод байдлыг хангах</p>	<p>а) Дотоод удирдлагын болон дотоод хяналтын системийг нэвтрүүлнэ</p> <p>б) Хэлтсийн үйл ажиллагааны зорилт, төлөвлөгөө, тайланг цахим хуудаст байршуулж, шинэчилж байх</p> <p>в) Мэдээллийн ил тод байдлыг хангаж статистикийн хэлтсийн ажил, үйлчилгээг цахим хэлбэрт бүрэн шилжүүлнэ</p> <p>г) Ажлын байрны сул орон тоо, ажиллаж буй ажилтны талаарх мэдээллийг ҮСХ-нд байнга мэдэгдэж, хэлтсийн цахим хуудаст байнга шинэчилж байршуулах</p>	<p>Хэлтсийн үйл ажиллагаа болон албан ёсны статистикийн мэдээллийг иргэдэд ил тод, шуурхай хүргэсэн байна.</p>
<p>3. Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах талаар:</p> <p>Зорилт-1: Санхүүгийн талаар хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа явуулахгүй байх.</p>	<p>а) Төсвийн төлөвлөгөө, зарцуулалтыг вэб хуудаст байршуулах, санхүүгийн тайлан мэдээг үнэн зөв гаргах.</p> <p>б) Аудитын газрын аудитын дүгнэлтийг ил тод бүрэн эхээр нь хэлтсийн портал сайтад байршуулна.</p>	<p>Төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан байна.</p>
<p>Зорилт-2: Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудит, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг ил тод мэдээлэх</p> <p>Зорилт-3: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, Санхүүгийн тайланг хугацаанд нь гарган тайлагнаж, хууль тогтоомжын дагуу үйл ажиллагаа явуулах.</p>	<p>в) Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн төсөв санхүүгийн ил тод байдлын мэдээллийн самбарт хэлтсийн жилийн санхүүгийн тайланг бүрэн эхээр, тухайн жилийн батлагдсан төсвийг сараар, сар бүрийн төсвийн зарцуулалтыг олон нийтэд нээлттэй байх зарчмыг баримтлан <a href="http://shilendans.gov.mn/">http://shilendans.gov.mn/</a> портал сайтад байршуулна.</p>	<p>Төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан байна.</p>

Манлайллын зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт
<p>4. Байгууллагын эд хөрөнгийг зохистой ашиглах талаар:</p> <p>Зорилт-1: Биет хөрөнгийн нөөцийг зохистой ашиглах.</p> <p>Зорилт-2: Үндсэн хөрөнгийн ашиглалтын талаар хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа явуулахгүй байх</p>	<p>а) Хэлтсийн эд хөрөнгийг ажилтан нарт хариуцуулан картална</p> <p>б) Эд хөрөнгийн тооллого, бүртгэлийг үнэн зөв хийх</p> <p>в) Үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах.</p>	<p>Мэдээлэл цуглуулах, боловсруулах, тархаах үе шатны хэвийн үйл ажиллагаа алдагдахгүй байх.</p>
<p>5. Байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх талаар:</p> <p>Зорилт-1: Одоо ажиллаж байгаа мэргэжилтнүүдээ тогтвор суурьшилтай ажиллуулах</p> <p>Зорилт-2: ҮСХ-ны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу ажилтнуудыг гадаад, дотоод сургалтад оролцуулах</p> <p>Зорилт-3: Ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулах</p>	<p>а) Төв орон нутгийн сургалт семинарт хариуцсан чиглэлийн дагуу оролцуулах</p> <p>б) Ажилтнуудын бие биеэ орон ажиллах чадварт сургах, дадлагажуулах ажлыг зохион байгуулах</p> <p>в) Хэлтсийн төсөв санхүүгийн одоогийн нөөц боломжийн хэмжээнд ажилтнуудыг урамшуулах, хариуцлага тооцох ажлыг хослон хэрэгжүүлнэ.</p>	<p>Ажилтны ажил гүйцэтгэх мэдлэг, ур чадвар дээшилнэ.</p>

1.4. Мэдлэг чадвараа дээшлүүлэх талаар дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ.

Хүснэгт 2	
Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт ( шалгуур үзүүлэлт)	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам (өөрийгөө хөгжүүлэх чиглэл ) Хуанлийн хугацаа, хүн/өдөр

<p>Мэдлэг чадвараа дээшлүүлэх</p> <p>Зорилт-1: Хэрэглээний зарим программын шинэ боломжийг ашиглах: (шалгуур үзүүлэлт)</p> <p>Ажилтан бүр</p> <ul style="list-style-type: none"> <li>• Excel, Word-ын 3-5 функц болон боломжийг шинээр сурч ажилдаа хэрэглэн бусдаа зааж өгөх,</li> <li>• MICROSOFT @ EXCEL номын 3-4 бүлгийг эзэмшиж судалгаа шинжилгээнд хэрэглэсэн байх</li> <li>• Devinfo программын шинэ боломжуудыг ашиглан сарын танилцуулгад хэрэглэх чадвар</li> </ul>	<p>a) Excel б) Word в) Devinfo г) MICROSOFT @ EXCEL</p> <p>номыг судалж эзэмшинэ.</p> <p>25</p>
<p>Мэдлэг чадвараа дээшлүүлэх</p> <p>Зорилт -2: Гадаад хэлний мэдлэгээ нэмэгдүүлэх (шалгуур үзүүлэлт)</p> <p>Ажилтнууд англи, орос, солонгос хэл дээр мэргэжлийн ном, хэвлэл, материал, гарын авлага ашиглах чадвартай болсон байх</p>	<p>39</p>

1.5. Төрийн албаны тухай хууль тогтоомж, стандартыг мөрдөж ажиллана.

## 2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг

2.1. Төсвийн шууд захирагчтай байгуулах гэрээнд тусгаж хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ (нийт болон тусгай арга хэмжээ)-нүүд, тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлно.

2.2. Манлайллын зорилтууд, тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлно.

2.3.Тухайн төрийн байгууллага болон эрх шилжүүлсний үндсэн дээр бусад байгууллага хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай төсвийг эрх бүхий байгууллагаар батлуулна.

2.4.Тухайн төрийн байгууллага болон эрх шилжүүлсний үндсэн дээр бусад байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг хугацаанд нь хийнэ.

2.5.Гэрээнд тусгагдсан хөтөлбөр, нийт болон тусгай арга хэмжээнүүд, манлайллын зорилтоо хэрэгжүүлэхэд нь төсвийн шууд захирагчид байнгын дэмжлэг туслалцаа үзүүлж, гэрээний биелэлтийг хангах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.

2.6. Монгол Улсын "Төсвийн тухай хууль"-ийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

- Улсын төсвийн санхүүжилтээр 93.304.5 мянган төгрөг

## ХОЁР. БУСАД ЗҮЙЛ

### 3. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

3.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэж, албажуулан гэрээнд хавсаргана. Энэхүү гэрээний хугацаа сунгагдахгүй.

### 4. Гэрээ байгуулах болон дүгнэх хугацаа:

4.1. Гэрээг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацаагаар байгуулав.

4.2. Төсвийн шууд захирагч гэрээний биелэлтийг 2015 оны 12 дугаар сарын 15-ны дотор багтаан тайлагнаж, төсвийн ерөнхийлөн захирагч 2015 оны 12 дугаар сарын 31-ний дотор багтаан түүний биелэлтийг дүгнэнэ.

### 5. Гэрээний урамшуулал ба хариуцлага

5.1. Төсвийн шууд захирагч гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлсэн тохиолдолд түүнийг урамшуулах асуудлыг төсвийн ерөнхийлөн захирагч холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэнэ.

5.2. Төсвийн шууд захирагч гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд төсвийн ерөнхийлөн захирагч түүнд холбогдох хууль, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

### 6. Гэрээ байгуулсан:

Төсвийн ерөнхийлөн захирагч

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН

ХОРООНЫ ДАРГА



СОНОМЦЭРЭНГИЙН МЭНДСАЙХАН

(албан тушаал)

(гарын үсэг)

(нэр)

Тэмдэг

2015 оны 03 дугаар сарын 17-ны өдөр

Төсвийн шууд захирагч

ТӨВ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН

ХЭЛТСИЙН ДАРГА



ЖҮГДЭРИЙН ОТГОНЧУЛУУН

(нэр)

Тэмдэг

2015 оны 03 дугаар сарын 17-ны өдөр